

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны санхүүгийн
тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/105/СТА-ТӨҮГ

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан.....	5
	2.1. Оршил.....	5
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	8
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	9
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	9
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
	2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл.....	10
	2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.....	10
	2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .	11
	2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	11
	2.11. Шилэн дансны мэдээлэл	12
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	12
	2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	12
3	Менежментийн захидал.....	13
	3.1 Эздийн өмчийн бусад хэсэг данстай холбоотой асуудал	15
	3.1.1 Илрүүлэлт:	15
	3.1.2 Эрсдэл:.....	15
	3.1.3 Өгсөн зөвлөмж:.....	15
	3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:.....	15
	3.2 Шилэн данстай холбоотой асуудал.....	16
	3.2.2 Илрүүлэлт:	16
	3.2.2 Эрсдэл:.....	16
	3.2.3 Өгсөн зөвлөмж:.....	16

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:.....	16
3.3 Зардлын данстай холбоотой асуудал	16
3.3.2 Илрүүлэлт:	16
3.3.2 Эрсдэл:.....	16
3.3.3 Өгсөн зөвлөмж:.....	16
3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:.....	16
4 Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	16
4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан.....	16
4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан.....	18
4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан	21
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА А.ТЛЕЙХАН
ТАНАА

2019.03.15 № 06/484
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Эрчим хүчний зохицуулах хороо нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Эрчим хүчний зохицуулах хорооны дарга А.Тлейхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Эрчим хүчний зохицуулах хорооны удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 20-ноос 2019 оны 03 дугаар сарын 11-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал, аудитын багийн ахлагч Т.Одончимэг, ахлах аудитор Б.Цогзолмаа чанарын хяналтын

менежер Э.Энхцэцэг, аудиторов туслах М.Сэржмядаг, Д.Эрдэнэбаяр, Т.Алтанчимэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны санхүүгийн тайланг 2019 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 8/268 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Эрчим хүчний зохицуулах хорооны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Эрчим хүчний зохицуулах хороо нь эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагааг зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлэн, Эрчим хүчний тухай хуульд заасны дагуу эрчим хүчний үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон хэрэглэгчийн тарифыг хянаж батлах, тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн эрх ашгийг тэнцвэртэй хамгаалах, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хүрээнд шударга өрсөлдөөнийг бий болгох нөхцлийг бүрдүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Эрчим хүчний зохицуулах хорооны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Үйл ажиллагааны чиглэл-1 Эрчим хүчний тухай хуулиар:

- Тусгай зөвшөөрөл олгох, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоох, хэрэгжилтийг хянах;
- Тариф тогтоох аргачлал боловсруулах, хянаж батлах, хэрэглэгчдэд худалдах үнийг тогтоох, индексжүүлэлтийг хэрэгжүүлэх;
- Эрчим хүчний хэрэглээг хамгийн бага өртгөөр хангах чадавхийг бүрдүүлсэн, зохих ашгийн түвшин бүхий үнэ тарифын тогтолцоог бий болгох;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн цахилгаан, дулаан дамжуулах, түгээх сүлжээг өргөтгөх, шинэчлэх, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хянаж, хөрөнгө оруулалтыг нөхөн төлөх асуудлыг тарифын зохицуулалтаар шийдвэрлэх;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигч болон хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг харъяаллын дагуу шийдвэрлэх;
- Хэрэглэгчид ирэх ачааллыг зохистой хэмжээнд хөнгөлөх зорилгоор тусгай зөвшөөрөл эзэмшигчид эрчим хүчний үнэ тарифын алдагдалтай холбоотой татаасыг улсын төсвөөс олгох асуудлыг Засгийн газарт оруулах;

Үйл ажиллагааны чиглэл-2 Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулиар:

- Дамжуулах сүлжээнд холбогдох үүсгүүр бүхий үйлдвэрлэгчийн үйлдвэрлэн нийлүүлэх эрчим хүчний тооцоог хянаж, хуулийн хүрээнд тарифыг батлах;
- Дамжуулах сүлжээнд холбогдох үүсгүүр бүхий үйлдвэрлэгчийн дамжуулагчтай байгуулах гэрээний загварыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

Үйл ажиллагааны чиглэл-3 Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулиар:

- Эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах, үндэсний хөтөлбөр боловсруулах;
- Үүрэг хүлээсэн хэрэглэгчээс эрчим хүчний хэрэглээ, хэмнэлтийн талаар тайлан гаргуулж, хянах;
- Эрчим хүчний аудитын байгууллага болон эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагад магадлан итгэмжлэл олгох, хүчингүй болгох;
- Эрчим хүчний аудитор, эрчим хүчний хэмнэлтийн менежерийн эрх олгох, бэлтгэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүргүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Эрчим хүчний зохицуулах хорооны удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын багц хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль
- Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль
- Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Нийгмийн даатгалын тухай хуульд ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 1 хувиар нэмэгдүүлсэн. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан татварын шатлалын өөрчлөлтийг мөрдөж байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Эрчим хүчний зохицуулах хорооны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Эрчим хүчний зохицуулах хороо санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Юникус” програм хангамж ашигладаг байна.

Эрчим хүчний зохицуулах хороо дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “үр нөлөөтэй” гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Эрчим хүчний зохицуулах хорооны бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 20 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 20 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгов.

Энэ нь тус байгууллагын хувьд үйлчилгээ үзүүлэх зорилготой төрийн байгууллага тул үйл ажиллагааны зардал нь үйл ажиллагааны цар хүрээг илтгэх хамгийн тохиромжтой үзүүлэлт гэж үнэлсэнтэй холбоотой юм.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 4,459.0 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 44.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь тус хорооны үйл ажиллагааны цар хүрээ, үйл ажиллагааны орлогын бүрдэлт, зарцуулалтад эрсдэл дунд байгаатай холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 9 чиглэлээр аудитын 24 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 20 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 4,135.0 сая төгрөгийн 5 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, Эрчим хүчний зохицуулах хорооны удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- Хүлээн авсан хүүний орлого мөнгөн гүйлгээний тайланд 9.6 сая төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн;
- 2018 оны 1, 4, 7 саруудад нийгмийн даатгалын шимтгэлд төлсөн 137.8 сая төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд даатгалын төлбөрт төлсөн мөнгөн хөрөнгийн ангилалд тайлагнасан;
- Тайлант онд 364.8 сая төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдлийг данснаас хассныг өмчийн өөрчлөлтийн тайланд тусгахдаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт алдааны залруулга хэсэгт тусгасан, мөн хуримтлагдсан ашиг хэсэгт нийт дүнг нэмэгдүүлсэн боловч холбогдох үзүүлэлтэд тухайн дүнг тусгаагүй;
- Тайлант хугацааны 3,620.6 сая төгрөгийн борлуулалтын өртгийг орлогын дэлгэрэнгүй тайланд ерөнхий ба удирдлагын зардалд тайлагнасан;
- Үндсэн хөрөнгийн элэгдүүлэх хугацааг татварын хуулинд зааснаас зөрүүтэй тооцсноос үүссэн 2.1 сая төгрөгийн хойшлогдсон татварын хөрөнгө үүсснийг тооцож бүртгээгүй зэрэг асуудлуудыг залруулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

/сая төгрөгөөр/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	152.1	
2	Албан шаардлага өгсөн	1	116.0	
	Дүн	4	268.1	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Тайлант онд 4 харилцагчтай холбоотой 114.0 сая төгрөгийн авлага, 2 харилцагчтай холбоотой 2.0 сая төгрөгийн өглөг, нийт 116.0 сая төгрөгийн өглөг, авлагыг барагдуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8-д “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч, ерөнхий нягтлан бодогч нь тооллого эхлэхийн өмнө дараахь бэлтгэл хангасан байх үүрэгтэй: Өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдэл: Албан шаардлага хүргүүлэх

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тус хороо нь 2017 онд 1,389.3 сая төгрөг, 2018 онд 840.9 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж байгаа нь эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг хуулиар олгогдсон эрх, үүргээ давуу байдлаар ашиглан өндөр тооцож авч байгаатай холбоотой гэж үзэн үйлчилгээний хөлсийг хэр үндэслэлтэй тогтоож байгаа талаар дараагийн аудитаар авч үзнэ.

Монгол Улсын Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу тус байгууллага 879.7 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй барилга байгууламжийг 977.2 сая төгрөгөөр, 1100 м2 хэмжээтэй эзэмшлийн гэрчилгээ бүхий газрыг 35.6 сая төгрөгөөр дахин үнэлж бүртгэлд тусгасан. Хөрөнгийн дахин үнэлгээний талаарх асуудлыг дараагийн аудитаар дахин хянах нь зүйтэй гэж үзэж байна.

Төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагын удирдлагууд, үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай Хамтын гэрээ байгуулж тус хэлэлцээрийн дагуу дараах нэмэгдлүүдийг ажиллагсад олгож байгаа нь Засгийн газрын чиг үүрэг, эрх хэмжээ, хууль, тогтоол, шийдвэр зөрчигдөхөд хүрч болзошгүй.

Тухайлбал 2-4 жил ажилласан хүнд удаан жилийн нэмэгдэл олгодог, сар бүр үр дүнгийн урамшууллыг хавтгайруулан олгож байгаа нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэмнэлттэй, үр ашигтай байх зарчим алдагдах эрсдэлтэй гэж үзлээ.

2.10. Зорилтот түвшингийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар удирдлага нь батлагдсан зорилтот түвшин, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Эрчим хүчний зохицуулах хорооны чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой 5 зорилтын хүрээнд 24 хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөж, арга хэмжээнд зориулан 2018 онд 5,140.0 сая төгрөгийн төсөв батлагджээ.

Гүйцэтгэлээр 5,299.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 4,458.3 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, 840.9 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Эрчим хүчний зохицуулах хороо Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ хэсэгт 1-3 сар “Хоосон”, 4-5 сар “Мэдээлэл байхгүй” 6-12 сарын мэдээлэл оруулах хэсэгт тухайн сарын гүйлгээг оруулах байтал сар бүр өссөн дүнгээрх гүйлгээг оруулсан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг оруулаагүй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Эрчим хүчний зохицуулах хорооны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Эздийн өмчийн бусад хэсэг данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Эх үүсвэр нь тодорхойгүй 66.1 сая төгрөгийн хөрөнгийг Эздийн өмчийн бусад хэсэг дансанд бүртгэсэн байна.

Энэ нь “бодитой оршин байх ба тохиолдсон байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 6-д “Эздийн өмчийн бусад хэсэг”-т Энэ хэсэгт бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрч өмчийн хэсэгт хуримтлуулан бүртгэсэн бусад олз, гарзын дүнг толилуулна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Эздийн өмчийн бусад хэсэг дансанд тодорхойгүй эх үүсвэр бүртгэлтэй байх,

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Эздийн өмчийн бусад хэсэг дансанд бүртгэлтэй 66.1 сая төгрөгийн үлдэгдэлд ногдох хөрөнгийн эх үүсвэрийг тогтоож, санхүүгийн тайланд залруулга хийх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Эздийн өмчийн бусад хэсэг болох 66.1 сая төгрөг нь 2005 оноос тус хорооны ажилтнуудад орон сууцны хөнгөлөлт олгохоор сан үүсгэж, түүнээсээ үндсэн хөрөнгөнд орон сууц орлогод авч бүртгэл хөтөлсөн. Орон сууц зарлагадах элэгдэл тооцогдож бүртгэлийн алдаа үүссэн тул цаашид өмнөх үеийн үр дүнд хаах саналтай байна.

3.2 Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчин

3.2.1 Илрүүлэлт:

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ хэсэгт 1-3 сар “Хоосон”, 4-5 сар “Мэдээлэл байхгүй” 6-12 сарын мэдээлэл оруулах хэсэгт тухайн сарын гүйлгээг оруулах байтал сар бүр өссөн дүнгээрх гүйлгээг оруулсан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг оруулаагүй.

Энэ нь Тодруулга ба толилуулга батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ: 6.1.1.тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор”, 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Шилэн дансны тухай хуулийг зөрчих

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

2017 оны аудитын тайлангаар шилэн дансанд бүртгүүлэх, мэдээлэл оруулах зөвлөмж өгсөн. Уг зөвлөмжийг биелүүлэн 2018 оны 4 дүгээр сараас эхлэн шилэн дансанд бүртгүүлэн мэдээллээ оруулж байгаа бөгөөд өссөн дүнгээр оруулсан байна. Шилэн дансны мэдээллийг маягт бүрээр тухай бүр мэдээллийг шилэн дансанд тайлагнах хуваарь болон хариуцсан ажилтанг томилохоор тушаал гаргаж байна. Тушаалын биелэлт, хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг сайжруулахаар анхаарч ажиллаж байна.

3.3. Зардлын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Тус хороо нь байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайлан гараагүй, ажлын үр дүнг дүгнээгүй байхад 2018 оны 12 дугаар сарын 27-нд 70 ажилтанд 86.0 сая төгрөгийн жилийн ажлын үр дүнгийн шагналын урьдчилгааг хавтгайруулан олгосон байна.

Энэ нь “иж бүрэн байдал”, “тасалбар болголт” батламж мэдэгдэлүүдтэй нийцэхгүйгээс гадна Эрчим хүчний зохицуулах хорооны 2016 оны 117 дугаар тогтоолоор батлагдсан “Эрчим хүчний зохицуулах хорооны үндсэн цалин, шагнал урамшууллын журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан “Хорооны жилийн ажлын үр дүнгийн шагналын хэмжээг ЭХЗХ-ны захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан Хамтын гэрээнд заасан хэмжээ, тухайн жилд хорооноос дэвшүүлсэн зорилтуудын биелэлт, хорооны чиг үүргийг хэрэгжүүлсэн байдал зэргийг харгалзан Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэн тогтооно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Үргүй зардал гаргасан байх, ажиллагсдын ажлын үр дүнг буруу дүгнэсэн байх, шагнал олгох журамтай зөрчилдсөн байх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Байгууллагын тайлант оны ажлын үр дүн, зорилтот түвшний биелэлт дүгнэгдээгүй байхад шагналын урьдчилгаа олгохгүй байх, журамд шагналын урьдчилгаа олгоно гэж заагаагүй байгаа мөн шагналд урьдчилгаа гэж байх ёсгүйг анхаарч ажиллах.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Тус хорооны цалин, шагнал, урамшууллын журамд тухайн жилийн үр дүнгийн шагналыг дараа оны 2 дугаар сард багтаан олгоно гэж заасан. Уг журамд заасны дагуу Хорооны удирдах зөвлөл жилийн үр дүнг хэлэлцэж, 2018 оны 214 дүгээр тушаалаар жилийн үр дүнгийн хувийг тогтоосон. Өмнөх оны үр дүнг тасалж өгсөнтэй холбоотой 2018 онд цалингийн зардлын хэмнэлт гарсан тул 1 сарын үр дүнг олгосон. Цаашид үр дүнг хувааж олгох асуудлыг гаргахгүй байхад анхаарч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,682,791,498.72	562,986,618.19
1.1.2	Дансны авлага	413,004,378.23	426,441,849.28
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	245,651,759.86	175,924,266.69
1.1.4	Бусад авлага	9,547,877.60	3,751,200.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	10,895,904.15	10,787,885.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	26,940,963.00	190,614,385.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10		2,388,832,381.56	1,370,506,204.16
	Эргэлтийн хөрөнгийн дүн		
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,798,737,161.81	1,607,896,282.98
1.2.2	Биет бус хөрөнгө	3,894,000.00	40,667,000.00
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		2,074,026.97
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		1,486,148,328.00
1.2.9			
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,802,631,161.81	3,136,785,637.95
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,191,463,543.37	4,507,291,842.11
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	1,969,514.00	2,263,514.00
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	230,670,000.00	20,042,605.28
2.1.1.4	НДШ–ийн өглөг		

Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

2.1.1.5	Богино хугацаат зээл	4,266.12	
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	667,085,512.30	254,765,133.90
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	899,729,292.37	277,071,253.18
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	899,729,292.37	277,071,253.18
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	104,537,450.95	104,537,450.95
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	364,857,785.30	61,916,617.76
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	66,075,249.21	101,693,249.21
2.3.9	Хуримтлагдсан ашиг	2756263765.54	3,962,073,271.01
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	3,291,734,251.00	4,230,220,588.93
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	4,191,463,543.37	4,507,291,842.11

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	5,111,946,875.50	5,139,993,720.90
2	Борлуулалтын өртөг	0.00	3,620,642,262.57
3	Нийт ашиг(алдагдал)	5,111,946,875.50	1,519,351,458.33
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого	30,235,794.34	51,202,543.08
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	159,151,359.81	108,729,679.80
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	3,720,052,551.63	340,441,708.55
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	90,382.79	-105,247,111.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-212,643.89
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-251,548,501.50
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)	-6,923,092.16	
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,574,448,768.65	981,833,716.27
19	Орлогын татварын зардал	185,103,782.71	140,881,995.70
20	Татварын дараах ашиг (алдагдал)	1,389,344,985.94	840,951,720.57
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,389,344,985.94	840,951,720.57
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	1,389,344,985.94	840,951,720.57
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа тэмж төлөгдсөн капитал	Зөвхөн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрөнгийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	104,537,450.95		364,857,785.30		66,075,249.21	1,367,066,134.08	1,902,536,619.54
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						-147,354.48	-
Залруулсан үлдэгдэл	104,537,450.95		364,857,785.30		66,075,249.21	1,366,918,779.60	1,902,389,265.06
Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)						1,389,344,985.94	1,389,344,985.94
Бусад дэлгэрэнгүй орлого							-
Өмчид гарсан өөрчлөлт							-
Зарласан ногдол ашиг							-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн							-
2017 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	104,537,450.95		364,857,785.30		66,075,249.21	2,756,263,765.54	3,291,734,251.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны							-

Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

залруулга							
Залруулсан үлдэгдэл	104,537,450.95		364,857,785.30		66,075,249.21	2,756,263,765.54	3,291,734,251.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)						840,951,720.57	840,951,720.57
Бусад дэлгэрэнгүй орлого							-
Өмчид гарсан өөрчлөлт					35,618,000.00		35,618,000.00
Зарласан ногдол ашиг							-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			-302,941,167.54			364,857,785.30	61,916,617.76
2018 оны 12 - р сарын 31 - ний үлдэгдэл	104,537,450.95	-	61,916,617.76	-	101,693,249.21	3,962,073,271.41	4,230,220,589.33

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,747,741,255.45	5,042,982,032.36
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	5,687,691,458.08	4,455,882,774.64
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		155,249,074.76
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	26,471,468.36	20,050,417.00
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	33,578,329.01	411,799,765.96
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,021,156,656.05	4,570,421,841.08
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,458,289,240.62	2,587,525,907.06
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	494,455,893.99	566,668,970.21
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	73,450,291.53	432,047,253.60
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	23,732,184.36	55,679,820.45
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	50,525,455.89	90,002,647.30
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	667,337,888.62	714,034,124.30
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	4,071,342.00	6,695,096.53
1.2.9	Бусад мөнгөн зарлага	249,294,359.04	117,768,021.63
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,726,584,599.40	472,560,191.28
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	30,235,794.34	51,202,543.08
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	30,235,794.34	51,202,543.08
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.1.8			
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	240,192,200.00	1,643,862,255.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	240,192,200.00	1,641,882,255.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		1,980,000.00

Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.2.6			
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-209,956,405.66	- 1,592,659,711.92
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4			
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	496,272.22	0.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
3.2.5		496,272.22	
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-496,272.22	0.00
4	Валютын ханшийн зөрүү		294,640.11
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,516,131,921.52	- 1,119,804,880.53
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	166,659,577.20	1,682,791,498.72
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,682,791,498.72	562,986,618.19

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019.03.15	Аудитын нэр:	2018 оны санхүүгийн аудитын тайлан	Аудитын код:
				САГ-2019/105/СТА-ТӨҮГ

Шалгагдсан байгууллагын нэр:	Эрчим хүчний зохицуулах хороо	Сая төгрөгөөр
------------------------------	-------------------------------	---------------

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Эздийн өмчийн бусад хэсэг дансанд эх үүсвэр нь тодорхойгүй 66,075.2 мянган төгрөгийн үлдэгдэл бүртгэлтэй байна.	66.1	Зөвлөмж өгөх	Дарга Нягтлан бодогч	А.Тлейхан М.Мандах
2	Шилэн дансанд байршуулсан мэдээллийг шалгахад дараах асуудлууд илэрсэн. Үүнд: - Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг хэсэгт Өөр утга оруулсан - Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ хэсэгт 1-3 сар “Хоосон”, 4-5 сар “Мэдээлэл байхгүй” 6-12 сарын мэдээлэл оруулах хэсэгт тухайн сарын гүйлгээг бус сар бүр 1-ээс хойшхи сарын 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй гүйлгээг оруулсан байна. Зөвхөн тухайн сарын гүйлгээг оруулах - Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг оруулаагүй		Зөвлөмж өгөх	Дарга Нягтлан бодогч	А.Тлейхан М.Мандах
3	Тус хороо нь байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайлан гараагүй, ажлын үр дүнг дүгнээгүй байхад 2018 оны 12 дугаар сарын 27-нд 70 ажилтанд 86,048.5 мянган төгрөгийн жилийн ажлын үр дүнгийн шагналын урьдчилгааг олгосон байна.	86.1	Зөвлөмж өгөх	Дарга Нягтлан бодогч	А.Тлейхан М.Мандах

Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

4	Тайлант оны эцэст 2015, 2016 онд үүссэн 4 харилцагчтай холбоотой 114.0 сая төгрөгийн авлага, 2014 оноос өмнө үүссэн 2 харилцагчтай холбоотой 2.0 сая төгрөгийн өглөг, нийт 116.0 сая төгрөгийн өглөг, авлагыг барагдуулаагүй байна.	116.0	Албан шаардлага хүргүүлэх	Дарга Нягтлан бодогч	А.Тлейхан М.Мандах
	Нийт дүн	268.2			

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing.